



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/385

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Холбоо навигаци ажиглалтын албаны өрөөнүүдийн засварын ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Ё.Эрдэнэбат	Агаарын навигацийн бодлого зохицуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Алдар	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Батмөнх	Холбоо навигаци ажиглалтын албаны Техникийн төлөвлөлт, инженерингийн хэсгийн технологич инженер
	Х.Ганбаатар	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	М.Эрдэнэсүх	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Ё.Эрдэнэбат/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Бат-Алдар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН